

МОНГОЛЫН НАМЫН СИСТЕМИЙН
ИНСТҮҮЧЛЭЛ

Судлаачид:

Алтанхуягийн БАТ-ОРГИЛ

Ганхуягийн БАТХИШИГ

Зөвлөх:

Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

АГУУЛГА

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ТОВЧИЛСОН НЭР	5
ТАЛАРХАЛ	6
ӨМНӨХ ҮГ	7
УДИРТГАЛ	8
1 НАМЫН СИСТЕМ БА НАМЫН СИСТЕМИЙН ИНСТҮҮЧЛЭЛ	10
1.1 Намын систем	11
1.2 Намын системийн инстүүчлэл	14
2 МОНГОЛЫН НАМЫН СИСТЕМ БА ИНСТҮҮЧЛЭЛ	20
2.1 Монголын улс төрийн нам ба намын системийн үүсэл хөгжил	21
2.2 Монголын намын системийн инстүүчлэл	28
ДҮГНЭЛТ	37
НОМ ЗҮЙ	39
ХАВСРАЛТ	42
ДЕФАКТО ИНСТИТУТЫН ТУХАЙ	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Голлох хоёр намын сонгууль ба парламентад эзлэх хувь хэмжээ	24
Зураг 2. Зохист харьцааны индекс	26
Зураг 3. Монгол ба Зүүн Европын зарим орнууд дахь сонгуулийн үр ашигтай намын дундаж тоо	29
Зураг 4. Монгол ба Зүүн Европын зарим орнууд дахь парламентын үр ашигтай намын дундаж тоо.....	30
Зураг 5. Саналын хэлбэлзэл, 1992–2020 он.....	34
Зураг 6. Монгол ба Зүүн Европын зарим орнууд дахь саналын дундаж хэлбэлзэл.....	35
Зураг 7. Монгол ба Зүүн Европын орнууд дахь намын системийн хаалттай байдал.....	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Намын системийн төрлүүд	13
Хүснэгт 2. МУ Улс төрийн намын түүхэн хөгжил	22
Хүснэгт 3. Сонгогчдын тоо ба ирц	27
Хүснэгт 4. Үр ашигтай намын тоо.....	29
Хүснэгт 5. Фракцчиллын индекс	30
Хүснэгт 6. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиудын дүн.....	32
Хүснэгт 7. Монгол ба Зүүн Европын зарим орнууд дахь саналын хэлбэлзэл	33
Хүснэгт 8. Бүртгэлтэй улс төрийн намуудын жагсаалт	42
Хүснэгт 9. УИХ-ын ээлжит сонгуулиудын дүн.....	46
Хүснэгт 10. Монголын намын систем, шалгуур үзүүлэлтүүдээр, 1992–2020 он.....	47
Хүснэгт 11. Унгар, Литва орны намын системийн инстүүчлэлд үзүүлэх төсвийн санхүүжилтийн нөлөө	
Хүснэгт 12. Намын системийн хаалттай байдлын индекс: Монгол	

ТОВЧИЛСОН НЭР

Ардчилсан Холбоо Эвсэл	АХЭ
Ардчилсан Нам	АН
Бүгд Найрамдах Нам	БНН
Зөв Хүн Электорат Эвсэл	ЗХЭЭ
Монгол Ардын Нам	МАН
Монголын Ардчилсан Нам	МоАН
Монгол Ардын Хувьсгалт Нам	МАХН
Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам	МАСН
Монголын Социал Демократ Нам	МСДН
Монголын Уламжлалын Нэгдсэн Нам	МУНН
Монголын Үндэсний Дэвшлийн Нам	МУДН
Монголын Чөлөөт Хөдөлмөрийн Нам	МЧХН
Монголын Ногоон Нам	МНН
Иргэний Зориг Нам	ИЗН
Иргэний Зориг Ногоон Нам	ИЗНН
Та Бидний Эвсэл	ТБЭ
Шударга Ёс Эвсэл	ШЁЭ
Улсын Дээд Шүүх	УДШ
Улсын Их Хурал	УИХ
Улс Төрийн Нам	УТН
Сонгуулийн Ерөнхий Хороо	СЕХ
Эх Орон Ардчилал Эвсэл	ЭОАЭ
Эх Орон Нам	ЭОН

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд тусалсан Конрад Аденауэрийн сангийн (КАС) хамт олон гүн талархалаа илэрхийлье. КАС нь Германы Христосын Ардчилсан Холбоо намын дэргэдэх улс төрийн сан юм. КАС 1993 оноос хойш Монгол улсад Ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн сан билээ. Энэ удаагийн судалгаагаар Монгол Улсад ардчилсан тогтолцооны гол инстүүц болох Улс төрийн намын тогтолцоог хөгжүүлэхэд чухал хувь нэмэрээ оруулж байна гэж үзэж байна.

Мөн энэхүү судалгаанд туслалцаа үзүүлсэн Нотингхэймийн их сургуулийн профессор Фернандо Касал Бэртуад гүн талархал илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

Д.ЖАРГАЛСАЙХАН

*Гүйцэтгэх захирал
Дефакто институт*

ӨМНӨХ ҮГ

Аливаа улс орны хөгжил цэцэглэл, амар тайван, тогтвортой байдал улс төр, эдийн засгийн суурь инстүүцүүд хүртээмжтэй байхаас ихээхэн хамаардаг. Улс төр, эдийн засгийн эдгээр суурь инстүүцүүдийг монголынхоо хөрсөнд төлөвшүүлж, бэхжүүлэхийн төлөө хөндлөнгийн, хараат бус судалгаа шинжилгээ хийж, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар хувь нэмрээ оруулах зорилгоор 2017 онд Дефакто Институт байгуулагдсан билээ.

Орчин үеийн төлөөллийн ардчилсан тогтолцооны нэг гол суурь багана бол улс төрийн нам хэмээх инстүүц юм. Монгол Улсад сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хэд хэдэн удаагийн парламентын хямрал нүүрлэв. Эдгээр хямралууд зарим тохиолдолд улс төрийн намуудаас эхтэй, ихэнх тохиолдолд улс төрийн намуудаар дамжин илэрсэн юм. Улс төрийн намын хямрал бол төрийн, цаашлаад эдийн засгийн, араас нь нийгмийн хямрал болгодог домино нөлөөтэй гэдгийг монголчууд улам хүчтэй мэдэрч байна.

Олон нийтийн дунд явуулдаг жил бүрийн авлигын төсөөллийн

судалгаагаар монголын улс төрийн намууд хамгийн ихээр авлигажсан инстүүцүүдийн нэгээр тодорсоор байна. Үүнийг дагаад улс төрийн нам хэмээх инстүүцийн нэр хүнд, байр суурь нийгэмд ганхах болов.

Цаашид бид бүс нутагтаа ардчилал, хүний эрх, эрх чөлөөгөөрөө түүчээлэгч орон байх эсэх нь олон намын тогтолцоо төлөвшиж, бэхжихээс ихээхэн шалгаалах юм. Харин ардчиллыг бэхжүүлэхийн тулд намууд эхлээд нам дотоод ардчиллаа сайжруулах шаардлагатай болжээ. Бид нийтээрээ олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн цагаас эхлээд намуудыг шинэчлэх, төлөвшүүлэх талаар хэлэлцэж ярилцсаар ирсэн. Гэвч энэ нь чухам яг юуг хэлж байгааг ойлгож мэдэх, хэрэгжүүлэх тухай нийтээрээ баримт нотолгоотой, үр дүнтэйгээр хэлэлцэж, мэтгэлцэхгүй явсаар ирлээ.

Тиймээс Дефакто Институтын зүгээс УТ намын систем хэр зэрэг инстүүчлэгдэж байгааг ул суурьтай судлахаар шийдсэн. Ингээд бид Герман КАС сангийн тусламжтайгаар 2020 оны 3 дугаар сарын 6 сарын хугацаанд энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

*Дефакто Институтын Гүйцэтгэх захирал
Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН*

УДИРТГАЛ

Монгол Улс хоёр том авторитар дэглэмтэй улсуудын голд ардчилсан дэглэмд амжилттай шилжиж чадсан нь онцгой тохиолдол юм. Энэхүү шилжилтийг амжилттай явуулахад улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэснийг монголын ардчиллын талаарх судалгаа шинжилгээнүүдэд онцолсоор ирсэн. Зөвхөн монгол ч биш шинээр ардчилалд шилжсэн Латин Америк, Ази төдийгүй дэлхий даяар энэхүү шилжилтийг хийхэд улс төрийн намууд чухал үүрэгтэй оролцжээ.

Монгол улс Ардчиллын индексээр 6.5 оноогоор 62 дугаар байрыг эзэлж байна (Economic Intelligence Unit, 2020).

Улс төрийн нам хэмээх инстүүц ардчилсан улс төрд хамгийн гол тоглогч юм. Үүнийг судлаач Шатшнайдер (1942) 'Улс төрийн намууд орчин үеийн ардчиллыг бий болгосон. Иймд орчин цагийн ардчиллыг намуудгүйгээр төсөөлөшгүй' гэж хэлсэн байдаг.

Ардчилсан оронд төрийн эрх мэдэлд хүрэх замаар аливаа улс

төр, эдийн засаг, нийгмийн бодлого хэрэгжүүлэх гол суваг нь улс төрийн намууд байдаг. Энэ утгаараа Монгол Улсад цаашид ардчилал тогтвортой төлөвших эсэх нь намын системийн тогтвортой байдлаас ихээхэн хамаарч байна. Намын системийн инстүүчлэл нь эрүүл ардчилал төлөвших нэг гол нөхцөл болдог.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд амжилттай шилжихэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн хүчин зүйлүүдийн тоонд улс төрийн намууд зүй ёсоор тооцогддог. Түүнчлэн намууд ардчиллыг нураахад ч голлох үүрэгтэй байж болохыг судлаачид тэмдэглэж байна. Ялангуяа экстрим, популист улс төрийн намууд ардчиллын инстүүцүүдийг нураах, ухраах хүчин зүйл ч болж чаддаг гэдгийг манайхтай цуг шилжилт хийсэн Унгарын жишээ харуулсан.

Дэлхийд намын системийн инстүүчлэлийн талаарх судалгаанууд олноор гарч, ойлголт, агуулга төдийгүй хэмжигдэхүүнүүдийн хувьд ч улам боловсронгуй болж, хөгжсөөр байна. Тэр дундаа шинээр ардчилалд шилжсэн орнууд дахь намын

системийн тогтвортой байдлыг хэмжих зорилготой судалгаанууд олон гарсан. 1995 онд Скотт Мейнвэринг, Тимоти Скалли нар “Ардчилсан инстүүцүүдийг байгуулах нь: Латин Америк дахь намын системүүд” нэртэй бүтээлдээ намын системийн инстүүчлэл хэмээх ойлголтыг анх танилцуулж, Латин Америкийн 12 орны намын системийг шинжилж үзсэн байдаг. Үүнээс хойш шинээр ардчилалд шилжсэн орнууд тэр дундаа хуучин коммунист орнууд дахь намын системийн инстүүчлэлийг шинжилсэн олон төрлийн судалгаа хийгджээ. Энэ дотроос Аурель Круасонт, Филип Волкел нар 2010 онд Зүүн ба Зүүн Өмнөд Азийн ардчилсан орнууд дахь намын системийн инстүүчлэлийг харьцуулан шинжлэхдээ монголын жишээг анх удаагаа багтаасан юм.

Бид энэхүү судалгаанд монгол дахь намын системийн инстүүчлэлийг олон намын тогтолцоонд шилжсэн үе буюу 1990 оноос хойших УИХ-ын ээлжит сонгуулиудаар үечлэн авч үзлээ. Эхний хэсэгт намын систем, намын системийн инстүүчлэлийн

талаарх ойлголт ба түүний хэмжигдэхүүнүүдийг тайлбарлана. Харин хоёрдугаар хэсэгт Монгол дахь намын системийн үүсэл хөгжил ба намын системийн инстүүчлэлийг хэмжсэнээ танилцуулна.

Энэхүү судалгаа нь бодлогын судалгаа биш бөгөөд цаашид хэрхэх талаар дэлгэрэнгүй жор хэлэх боломжгүй. Харин өнөөдрийг хүртэл Монгол улсад намын систем хэрхэн хөгжсөн гэдгийг харуулах зорилготой судалгаа юм. Өөрөөр хэлбэл норматив биш позитив судалгаа гэсэн үг.

Бид Монголд ардчилсан улс төрийн тогтолцоо цаашид тогтвортой хөгжихөд хувь судалгаагаараа хувь нэмрээ оруулж байгаа гэдэгт гүнээ итгэж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

**Монголын намын систем,
намын системийн инстүүчлэл,
сонгууль,**



**НАМЫН СИСТЕМ БА
НАМЫН СИСТЕМИЙН
ИНСТУУЧЛЭЛ**

1.1 НАМЫН СИСТЕМ

Улс төрийн нам бол ардчилсан инстүүцүүдийн нэг бөгөөд бие даасан систем юм. Энэ системийг олон талаас нь эрдэмтэн судлаачид тодорхойлж судалсан байдаг. Намын систем судалдаг судлаачид дотроос Дуверже онцгой байр суурь эзэлнэ. Дуверже 1954 онд анх улс төрийн намын системийг намуудын тоо, хэмжээ, холбоо, газар зүйн байршил, улс төрийн тархац зэргээр тодорхойлсон байдаг. Түүний тодорхойлолт өрсөлдөж буй намуудын тоог хамгийн ихээр онцлон авч үздэг. Энэхүү ангиллаар үндсэндээ хоёр төрлийн намын систем байна гэж үзэж болно. Нэг нь хоёр намын систем, нөгөө нь олон намын систем (Дуверже 1954). Ерөөсөө улс төрийн намын систем хэр зэрэг төлөвшсөн гэдгийг харуулахдаа сонгуулийн үр дүнд хэдэн нам парламентад суудал авч байгаар хэмжиж, тодорхойлдог. Харин Дувержегээс ялгаатай тодорхойлсон хүн бол Рэй (1967) бөгөөд тэрээр улс төрийн намын системийг намууд хоорондын өрсөлдөөний холимог үр дүн гэж тодорхойлжээ.

Орчин үеийн улс төрийн нам судлалын эцэг хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн Ирландын судлаач Петер Мейрийн (1997) томъёолсноор дөрвөн удаагийн улс төрийн намын системийн давалгаа

бий болжээ. Эхний үе XX зууны эхэнд бүх нийтийн (эрэгтэй, эмэгтэй) сонгуулийн эрх бий болохтой зэрэгцээд гарч ирсэн. Хоёр дахь давалгаа нь 1940-1950-иад оны үед Европт буюу Австри, Баруун Герман, Итали гэх мэт орнуудад авторитар дэглэм нуран унасантай холбоотойгоор гарч иржээ. Харин гурав дахь давалгаа 1970-иад оны үед Грек, Португал, Испани зэрэг орнуудад өрнөсөн. Эцэст нь 1990-ээд оны үед коммунизм нуран унаснаар дөрөв дэх давалгаа бий болжээ.

Улс төрийн намын систем бол бие биенийгээ дэмжсэн эсвэл үгүйсгэсэн шийдвэрүүд ч дангаараа биш, аль эсвэл бичигдсэн дүрэм журмуудын нийлбэр ч дангаараа биш юм. Улс төрийн намын систем бүрдэхэд үндсэн хууль, үндсэн хуулийн байгууламжууд, хамгийн гол нь олон мянган сонгогчдын сонголт, сонгуулийн хууль, дүрэм журмууд чухал нөлөөтэй. Гэхдээ энэ бүх дүрэм журмууд нь улс төрийн элитүүдийн үйл ажиллагаа, шийдвэрүүдийн нөлөөн дор бий болдог байна (Касал Бэртуа, Энеди 2018). Тийм ч учраас улс төрийн намын системийг сонгуулийн тогтолцоотой холбон авч үзэх нь түгээмэл байдаг. Тухайлбал сонгуулийн хоёр өөр тогтолцоонд аль нь хэдэн нам бүхий системийг

бий болгож байгаа нь тодорхой ялгарч харагддаг. Пропорциональ сонгуулийн систем нь плюраль, мажоритар системтэй харьцуулахад илүү олон намуудыг гаргаж ирэх жишээтэй.

Сүүлийн 40-50 жилд сонгуулийн хууль, тогтолцоо нь улс төрийн намын тогтолцоонд хэрхэн нөлөөлдөг талаар олон төрлийн онолууд гарч иржээ. Гэвч энэ онолуудын дийлэнх нь барууны төлөвшсөн ардчилалтай орнуудад зориулагдсан байдаг. Хуучин коммунист орнуудад шинээр байгуулагдсан намын системийн талаарх судалгаа, онол хангалттай олон биш. Ер нь пост коммунист орнуудад шинээр гарч ирсэн намууд эхний хэдэн сонгуулиудаар ялагдсан явдал нь коммунист нэг намын тогтолцооны нөлөө удаан үргэлжилдэг болохыг харуулдаг гэж үздэг. Пост коммунист орнуудын улс төрийн намын систем нь иргэний нийгэм маш сул буюу дөнгөж бүрдэж байх үед бий болсоноороо онцлогтой байдаг. Тийм учраас иргэний нийгэм тодорхой хэмжээнд хөгжчихсөн байсан орнуудаас ихээхэн ялгаатай дүр зураг харагддаг. Ер нь шинэ тутам ардчилал бий болсон орнуудад нийгмийн зааг ялгарал хүчтэй бүрэлдээгүй байдаг нь улс төрийн намын системийн төлөвшилд нөлөөлдөг байна (Mair 1997).

Улс төр судлаач Дувержегийн тодорхойлсноор пропорциональ систем нь үндэсний хэмжээний намын

төлөвшлийг дэмждэг бөгөөд орон нутаг дахь өрсөлдөөнийг ойролцоо түвшинд хадгалдаг. Пост коммунист орнуудад 3-8 хувийн босготой пропорциональ тогтолцоогоор сонгууль хийж ирсэн нь намуудын тоог хязгаарлах хүчин зүйл болсон бөгөөд улс төрийн намын системийг царцаах нөлөө үзүүлсэн гэж Бөрк (2003) дүгнэжээ. Харин сонгуулийн холимог системийн үр нөлөө мөн л ялгаатай. Холимог систем нь плюраль, мажоритар болон пропорциональ системийн завсарын улс төрийн намын системийг бий болгосон гэдэг (Рейнолдс, Рейлли 1997). Мажоритар сонгуулийн тогтолцоо нь нэр дэвшигчид тухайн орон нутагтаа хүчтэй дэмжлэгтэй байхыг шаарддаг бөгөөд улс төрийн намын хамаарал тийм ч хүчтэй бус байдаг. Харин улс төрийн намын жагсаалт нь улс төрийн намыг байгууллагын хувьд нэн тэргүүнд тавьдаг. Энэ хоёр төрлийн сонгуульд өөр өөр төрлийн хүмүүс нэр дэвшдэг болохыг Унгар, ОХУ-ын сонгуулиас харж болно (Birch 2003).

Хүмүүс улс төрийн намыг цаг хугацааныхаа явцад төлөвшинө гэж хүлээдэг ба үнэхээр ч цаг хугацаа өнгөрөх тусам намуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа нь тогтворжиж ирдэг. Улс орон бүрт намууд хоорондоо ихээхэн ялгаатай төдийгүй тодорхой цаг үе, бүс нутаг зэрэг олон хүчин зүйлээс хамаарч төлөвшиж байдаг.

Хүснэгт 1. Намын системийн төрлүүд

Зохиогч	Ангиллын үндсэн шалгуур	Тодорхойлсон намын системийн үндсэн төрөл
Дюверже (1954)	намуудын тоо	хоёр намын систем
		олон намын систем
Даал (1966)	сөрөг хүчний өрсөлдөөн	нягт өрсөлдөөнтэй
		хамтын ажиллагаатай-өрсөлдөөнтэй
		эвслийн-өрсөлдөөнтэй
		нягт эвслийн
Блондел (1968)	намуудын тоо	хоёр намын систем
	намуудын харьцангуй хэмжээ	хоёр ба хагас намын систем
		нэг намын давамгайлал бүхий олон намын систем
		давамгайлсан намгүй олон намын систем
Роккан (1968)	намуудын тоо	Британи-Германийн '1 vs. 1 +1' систем
	нэг нам олонх болох магадлал	Скандинавийн '1 vs. 3-4' систем
	цөөнх намын хүчний хуваарилалт	тэгш олон намын систем '1 vs. 1 vs. 1 +2-3'
Сартори (1976)	намуудын тоо	хоёр намын систем
	үзэл баримтлалын ялгаа	олон талт байдал тогтсон олон талт байдал хуваагдсан

Эх сурвалж: (Mair, 1997, 202)

1.2 НАМЫН СИСТЕМИЙН ИНСТҮҮЧЛЭЛ

Улс төрийн намын инстүүчлэл хэмээх сэдэв судлаач Скотт Мейнвэрингийн бүтээлээс үүдэлтэйгээр судалгааны нэг чухал чиглэл болон гарч ирсэн. Үүнд Скалли, Торсал, Зоко зэрэг судлаачид чухал хувь нэмэр оруулжээ. Тэдний судалгаануудын үр дүнд улс төрийн намын инстүүчлэл бол улс төрийн намын системийн суурь гэж хүлээн зөвшөөрөгдөх болсон юм. Касал Бертуа (2012) улс төрийн намын системийн инстүүчлэлийг улс төрийн намуудын харилцаа цаг хугацааны явцад тогтворжиж, урьдчилан таамаглахуйц, хэвшмэл болох үйл явц гэж тодорхойлжээ. Улс төрийн намын инстүүчлэлийг хэмжих олон хэмжүүр байгаа бөгөөд дараах гол гурван хүчин зүйлүүд байна (Касал Бертуа ба Энеди, 2018).

1. Улс төрийн намуудын тогтвортой байдал
2. Сонгогчдын зан төлвийн тогтвортой байдал
3. Улс төрийн системийн ялгарал (Үүнийг үр ашигтай улс төрийн намын тоогоор хэмждэг)

Дараах нөхцөлд улс төрийн намын систем сул инстүүчлэгдсэн гэж үзнэ.

1. Төр засгийн эрх мэдлийг авах сонголтын хувилбарууд бараг байхгүй байх
2. Хувилбар сонголтууд нь тогтвортой болоогүй байх
3. Засгийн эрх авах магадал бараг бүх намд адилхан байх

Нөгөө талаасаа улс төрийн намын систем нь дараах нөхцөлд инстүүчлэгдсэн гэж үзнэ.

1. Альтернатив хувилбартай байх
2. Тэр альтернатив хувилбар нь тогтвортой, танил байх

Ерөнхийдөө инстүүчлэл гэдэг бүтэц, зохион байгуулалт эсвэл үйл ажиллагааны хувьд тогтвортой болж, хүлээн зөвшөөрөгдөх үйл явц юм. Харин Самуэл Хантингтон (1968) инстүүчлэлийг байгууллага, процедур нь үнэт зүйл, тогтвортой байдал олж авахыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Тогтвортой улс төрийн намын систем гэдэг бол хэмжээ, бүтэц, бүр нэр нь хүртэл тогтвортой байдаг. Мейнвэринг, Скалли (1995) нарын тодорхойлсноор инстүүчлэгдсэн улс төрийн намын систем бол дараах дөрвөн гол нөхцлийг хангадаг.

Нэгт. Намууд хоорондын

	өрсөлдөөн тогтворжих (Үүнийг Педерсений индексээр хэмждэг)	үнэмшилтэй, намдаа үнэнч байх, дүрэм, журам нь тогтсон байх нь ч бас чухал. Ер нь нам нь байгууллагын хувьд хэр удаан, тогтвортой үйл ажиллагаа явуулж буй эсэх нь нөлөөлдөг. Ерөнхийдөө инстүүчлэгдсэн намын системд улс төрд намууд хамгийн гол тоглогчид гэдгийг хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Одоо бид намын системийн инстүүчлэлтэй холбоотой гол нэр томъёо, ойлголтууд, тэднийг хэрхэн хэмждэг талаар нэг бүрчлэн танилцуулна.
Хоёрт.	Улс төрийн намууд нийгэмд тогтвор суурьтай байх. (Иргэдтэй ойр байх)	
Гуравт.	Голлохулстөрийнхүчнүүд хүлээн зөвшөөрөгдсөн байх (Мэйверинг, Скалли, 1995)	
Дөрөвт.	Намууд бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхжих	
	Намын лидерүүд нь итгэл	

Саналын хэлбэлзэл (Electoral Volatility)

Аливаа намын системийн тогтвортой байдлыг хэмждэг гол шалгуур үзүүлэлт бол сонгогчдын саналын хэлбэлзэл юм. Энэхүү хэмжүүрийг анх 1979 онд Могенс Педерсен танилцуулсан бөгөөд энэ хэмжүүрээр нэг сонгуулиас нөгөө сонгуулийн хооронд намын системд гарсан өөрчлөлтийг тодорхойлдог. Педерсен (1979) намын системд гарч буй өөрчлөлтийг дараах гурван түвшинд тодорхойлж болно гэж үзсэн. Үүнд:

1. Парламент, засгийн газрын түвшинд,
2. Намын байгууллагын түвшинд,
3. Сонгогчдын түвшинд

Ийнхүү тэрээр намын системд гарч буй цэвэр өөрчлөлтийг хэмжихийн тулд сонгогчдын саналын хэлбэлзэлд илүү ач холбогдол өгсөн байдаг. Индексийг тооцоходоо намуудын нэг сонгуулиас нөгөө сонгуульд авсан саналын

зөрүүнүүдийн нийлбэрийг хоёрт хувааж гаргадаг (Pedersen, 1979).

Саналын хэлбэлзэл бага байх тусмаа тухайн намын системийг тогтвортой гэж үзнэ. Уг хэмжигдэхүүн нь нэг намаас нөгөө намд шилжсэн саналын хэмжээг харуулахаас гадна голлох намуудын нийгэмд эзлэх байр суурь, хэмжээг гаргаж ирдэг ач холбогдолтой (Krupavicius, 2004).

$$\text{Саналын хэлбэлзэл} - TV = \frac{|P_iV| + |P_jV| + |P_kV| + |P_eV| + \dots + |P_nV|}{2}$$

Үр ашигтай намын тоо (Effective number of parties)

Улс төрийн намын системийн инстүүчлэлийг хэмжихэд бас нэг чухал үзүүлэлт бол үр ашигтай намын тоо юм. Намын системийн тогтвортой байдал нь намууд хэр зэрэг фракцад хуваагдсан, намын чадавх, халаа сэлгээ зэргээр тодорхойлогддог. Рэйгийн фракцчиллын индекс, Лааксо, Таагерерагийн үр ашигтай намын тоо зэрэг нь тус хэмжүүрийн үндсэн жишээнүүд юм.

Фракцчиллын индекс

Намын систем /сонгуулийн/

$$F=1 - (\Sigma T^2) \quad T = \frac{\text{тухайн намд өгсөн нийт санал}}{\text{бүх намуудын авсан нийт санал}}$$

Намын систем /Парламентын/

$$F=1 - (\Sigma S^2) \quad S = \frac{\text{тухайн намын авсан суудлын тоо}}{\text{парламент дахь нийт суудлын тоо}}$$

Лааксо, Таагерера нар үр ашигтай намуудын тоо хэмээх ойлголтыг Рейгийн фракцчиллын индекс дээр суурилж, 1979 онд анх гаргасан байдаг. Энэхүү индексээр тухайн орны үр ашигтай намуудын тоог парламентад авсан суудлын тоо, сонгуулиар авсан саналын тоонд үндэслэж гаргадаг.

Сонгуулийн үр ашигтай намын тоо нь:

$$N_v = \frac{1}{\Sigma (P_v)^2} \quad P_v \text{ нь намын авсан саналын хувь хэмжээг илэрхийлнэ.}$$

Парламент дахь үр ашигтай намын тоо нь:

$$N_s = \frac{1}{\Sigma (P_s)^2} \quad P_s \text{ нь намын авсан суудлын хувь хэмжээг илэрхийлнэ}$$

Намын системийн хаалттай байдал (Party system closure)

Улс төрийн намын системийн инстүүчлэлийг хэмжих бусдаас ялгардаг эрдэмтэд бол Петер Мэйр, түүний шавь Фернандо Касал Бертуа нар юм. Ялангуяа Фернандо Касал Бертуа уг сэдвээр хамгийн олон судалгааны бүтээл туурвижээ.

Тэдний үзэж байгаагаар намын системийн инстүүчлэлийг хэмжихэд засгийн газрын төлөөх намууд хоорондын өрсөлдөөн хамгийн чухал байдаг. Үүнд дараах хүчин зүйлүүдийг тооцож үздэг.

- 1) Засгийн газрын бүрэлдэхүүн (alternations of governments),
- 2) Засгийн бүрэлдэхүүн удаан хугацааны туршид тогтвортой байх,
- 3) Зарим намууд (гадна талын тоглогчид) засгийн бүрдүүлэхэд оролцдоггүй байх

Дараах гурван нөхцөлд сул инстүүчлэгдсэн гэж үзнэ.

- а. Засгийн бүрэлдэхүүнд хагас солигддог байх
- б. Засгийн бүрэлдэхүүнд тогтмол ордог намуудгүй байх
- с. Засгийн бүрэлдэхүүнд орох боломж бараг бүх намд нээлттэй байх (Mair 1997, 2001).

Энэ хүрээнд 1) засгийн газрын бүрэлдэхүүнийг хэмжихдээ Пэдерсений саналын хэлбэлзлийн индекс дээр суурилсан засгийн газрын бүрэлдэхүүний индекс (index of government alternation)-ийг ашигладаг. Засгийн газар өөрчлөгдөх бүрт тухайн засгийн газрын нам тус бүрт оногдох цэвэр өөрчлөлтийн нийлбэрийг гаргаж, хоёрт хуваана.

Намын системийн хаалттай байдал (closure) гэх ойлголт нь засгийн газрын түвшинд намууд хоорондын харилцаа хэр тогтвортой буйг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл засгийн газар байгуулах үйл явц тогтсон хэдэн намаар хязгаарлагдаж буй тохиолдолд тухайн намын системийг хаалттай гэж үзнэ. Уг ойлголтыг Петер Мейр анх гаргаж ирсэн бөгөөд намын системийн хаалттай байдал дараах гурван хүчин зүйлээс хамаарна гэж үзжээ.

1. Засгийн газрын бүрэлдэхүүн (Alternation in government)
2. Хэвшмэл засгийн газар (Governing formulae)
3. Засгийн газрын нээлттэй байдал (Access to government)

Засгийн газрын бүрэлдэхүүний индекс

Уг индексийн дагуу засгийн газар солигдоход дараах гурван үндсэн хэв шинжийг агуулна гэж үздэг. Нэгт засгийн газар солигдоход өмнөх эрх баригч намаас тэс өөр намууд шинэ засгийн газрыг бүрдүүлж буй тохиолдолд бүхэлдээ солигдох (wholesale) гэсэн хэв шинжид хамаарна. Хоёрт өмнө нь засгийн газарт багтаж байгаагүй намууд болон өмнөх засгийн газарт багтаж байсан намууд нийлж бүрдүүлж буй тохиолдолд хэсэгчлэн солигдох (partial) гэсэн хэв шинжид хамааруулна. Гуравт шинэ засгийн газар өмнөх эрх баригч намаас бүрдэж буй тохиолдолд огт солигдоогүй (non-alternation) гэсэн хэв шинжийг илэрхийлнэ.

Хэвшмэл бүрэлдэхүүний индекс

Энэхүү индексээр намуудын засгийн газраа бүрдүүлж буй байдал хэвшмэл эсвэл шинэлэг эсэхийг хэмждэг. Хэрэв тогтсон хэдэн намууд хамтарч засгийн газраа байгуулдаг тохиолдолд хэвшмэл буюу тухайн системийг хаалттайд тооцно. Харин засгийн газар өмнө нь хамтарч засгийн эрхийг хэрэгжүүлж байгаагүй намуудаас бүрдэж буй тохиолдолд шинэлэг буюу системийг нээлттэй гэж үзнэ.

Засгийн газрын нээлттэй байдал (Access to Government)

Бас нэг чухал үзүүлэлт бол засгийн газрын нээлттэй байдал. Үүнд нэг талаасаа бүх л намууд нь засгийг бүрдүүлэхэд оролцдог байх, нөгөө талаасаа зарим намууд нь хэзээ ч тэр бүрэлдэхүүнд орохгүй байх тухай юм. Хаалттай байна гэдэг нь хуучин засаглаж байсан намууд л засагладаг байх тухай гэж ойлгож болно.

Зохист харьцааны индекс

Майкл Галлагерийн боловсруулсан уг индекс нь намуудын авсан санал ба намуудад хуваарилагдсан суудлын хувь хэмжээний тэнцвэрийг тооцоолдог. Өөрөөр хэлбэл тухайн намд хуваарилагдсан парламентын суудлын тоо нь сонгуулиар нийт авсан саналынхаа хэмжээнд дүйцсэн эсэхийг тодорхойлох зорилготой юм.

Зохист харьцааны индексийг тооцохдоо:

$$LS_q = \sqrt{\left(\sum_i (s_i - v_i)^2\right) / 2}$$

$S_i - V_i$ нь авсан суудлын хувь хэмжээ ба саналын хувь хэмжээний зөрүүг илэрхийлнэ.

Дээрх хэмжүүр үзүүлэлтүүдийг судлаачид янз бүрээр ашигладаг бөгөөд тухайн судлаачийн итгэл үнэмшил, байр сууринаас хамаарч ихэвчлэн хэрэглэгддэг байна. Тиймээс заавал дээр дурдсан бүх үзүүлэлтүүдийг тооцдоггүй. Жишээлбэл Петер Майр, Фернандо Касал Бертау нар бол зөвхөн намын системийн хаалттай байдал гэдэг дээрх үзүүлэлтээр тухайн намын системийг нь хэмжээд хэр зэрэг инстүүчлэгдсэн байгааг нь тодорхойлчихдог. Энгийнээр илэрхийлбэл цөөн тооны хэдэн улс төрийн намууд л засгийн эрхийг ээлжлэн авч, засгаа байгуулж байгаа эсэхийг л хэмжихэж байгаа юм. Ингэснээр иргэд сонгогчид сонгуулиар намд хариуцлага тооцоход хялбар болж байна гэсэн үг юм.



МОНГОЛЫН НАМЫН
СИСТЕМ БА НАМЫН
СИСТЕМИЙН ИНСТУУЧЛЭЛ

2.1 МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМ БА НАМЫН СИСТЕМИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Монгол Улсад орчин үеийн төлөөллийн ардчиллын гол инстүүц болох улс төрийн нам үүсч, хөгжсөнийг түүхэн цаг үетэй нь холбон тайлбарлах шаардлагатай. Монголд анхны нам 20-р зууны эхээр бий болжээ. Энэ үед дэлхий дахинаа нэг намын авторитар дэглэмийн дор коммунист үзэл суртлыг дэлгэрүүлж эхэлсэн байдаг. Орчин үеийн улс төрийн намын хэв шинжийг агуулсан анхны нам 1921 онд ‘Монгол Ардын Нам’ нэртэйгээр тусгаар тогтнолоо сэргээх, төрт улсаа байгуулах зорилгоор үүсгэн байгуулагдаж байв. Удалгүй бүс нутгийн улс төрийн нөхцөл байдлын нөлөөгөөр ‘Монгол Ардын Хувьсгалт Нам’ болгон нэрээ өөрчилсөн. Ингээд Монголд нэг намын авторитар дэглэмийн эхлэл тавигджээ.

Гэхдээ уг нам анх үүсгэн байгуулагдахдаа олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч байсан талаар Д.Болд-Эрдэнэ (2000) дурдсан байдаг. Тухайлбал *“Монголын ард*

олны эрх мэдлийг эрхэмлэх, монголын төрийг босгох хэмээсэн энэхүү хоёр зүйлийн хэргийг бүрэн бүтэн гүйцэтгэхэд манай Ардын намаас цаг үеийг үзэж, бошгийг халах намын бат журмаар үйлдэнэ. Хэрвээ Монголын өөр үзэл суртлын намууд гарч ирээд манай уул хоёр хэрэгт тусламаар аваас мөнхүү тэдгээр намууд лугаа тухайд түр хэлэлцэж хүчин хавсарсугай” гэжээ (Д.Болд-Эрдэнэ, 2000, х. 179).

Улмаар авторитар дэглэм оршин тогтносон 70 шахам жилд нэг нам засгийн эрхийг дангаар барьж ирснээс гадна өөр улс төрийн нам, хүчин бүртгүүлж үйл ажиллагаа явуулахыг огт хүлээн зөвшөөрөөгүй. Намын систем гэдэг хэд хэдэн нам (багадаа хоёр нам) хэвшмэл байдлаар хоорондоо харилцан нөлөөлж, оршин тогтнохыг хэлдэг (Сартори, 1976). Иймээс монгол дахь нэг намын тогтолцооны түүхэн үеийг намын системд тооцох боломжгүй юм.

Хүснэгт 2: Монголын Улс төрийн намын түүхэн хөгжил

Өмнөх үе	Өнөө үе
Монголд нам гэх субъект 1921 оны 3 сард байгуулагдаж 7 дугаар сараас засгийн эрхэнд гарсан.	1990 оны 2 дугаар сард Ардчилсан нам байгуулснаа зарласан.
1940 онд МАХН-ийг үндсэн хуулиараа улсын бүх байгууллагыг удирдах гол хүчин гэж зарласан	1960 оны 5 сард Улс төрийн намын тухай хууль баталж, намуудыг УДШ бүртгэх тухай дурдсан.
1960 оны Үндсэн хуулинд МАХН намын улс төрийн идеологи ямар байхыг заажээ.	1990 онд таван нам байгуулагдаж Дээд шүүхэд бүртгүүлжээ. Үүнд МоАН, МСДН, МҮДН, МНН, МЧХН багтана
	1990 онд 6 нам оролцсон сонгуулийг 5 хувийн босготой пропорциональ тогтолцоогоор зохион байгуулсан.
1949 оноос АИХ-ын сонгуулийг 1986 он хүртэл нийтдээ 11 удаа зохион байгуулсан. Уг сонгуулиуд бүгд өрсөлдөөнгүй сонгууль болж байсан.	1990 онд сонгуулийн тухай хуулийг өөрчилж, ардчилсан сонгууль явуулах эхлэлийг тавьсан.

(Эх сурвалж: Б.Чимид, 2006)

Харин 20-р зууны төгсгөлд коммунист дэглэм нуран унаснаар Монголд олон намын ардчилсан тогтолцоо, намын систем бий болов. 1990 онд Улс төрийн намын тухай, 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа тус тус баталснаар олон намын тогтолцоог эрх зүйн хувьд баталгаажуулсан юм. Ингэснээр сөрөг хүчин, бусад улс төрийн намууд албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах боломж бүрджээ. Үүний дагуу эрх барьж байсан МАХН хуучин намын залгамж халааг үргэлжлүүлж,

шинээр бүртгүүлсэн бол дараа нь МоАН, МНН, МҮДН, МСДН, МЧХН зэрэг намууд бүртгэгдэж, олон намын тогтолцоо биеллээ олсон байна. Удо Баркманн (2005) шилжилтийн үед шинээр үүсгэн байгуулагдсан эдгээр намууд ардчилал, улс төрийн олон ургалч үзлийн илэрхийлэл болсныг тэмдэглэжээ.

Улмаар 1990 онд анх удаагаа олон намын өрсөлдөөнт сонгууль зохион байгуулагдсан. Нийтдээ зургаан улс төрийн нам өрсөлдсөн ч эрх баригч

МАХН парламентын үнэмлэхүй олонхийг бүрдүүлэв. Энэ сонгууль холимог тогтолцоогоор явагдсан нь намын системийн үндсийг тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн Д.Болд-Эрдэнэ (2000) дүгнэжээ. Үр дүнд нь шинээр байгуулагдсан намуудаас гурав нь парламентад суудалтай болсон юм. Фритц (2002) монголын ардчилсан шилжилтийг 'эрх баригчдын удирдлаган дор хийсэн шилжилт' гэж тодотгосон байдаг. Энэ нь шилжилтийн эхэн үед өмнөх эрх баригч нам цорын ганц томоохон улс төрийн хүчин хэвээр байсантай шууд холбоотой. Мөн бусад улс төрийн нам, хүчнүүд бүтэц, зохион байгуулалтын хувьд хараахан бэхжиж амжаагүй байсныг илэрхийлнэ.


Стивэн Фиш (1998) Монголын улс төрд өмнө нь ямарваа нэг лидер бус нам ноёрхож байсан нь намын систем хурдацтай төлөвшиж, ардчилсан шилжилтэд чухал нөлөө үзүүлснийг онцолжээ. Үүнээс гадна тэрээр хуучин коммунист орнууд дотроо Монголын намын системийг хамгийн төлөвшсөн намын систем хэмээн тодотгосон байдаг (Fish 1998: p. 135).

Монголын намын системийг АН, МАН гэсэн хоёр голлох нам

тодорхойлж ирсэн. Гэхдээ хорьдугаар зууны монголын улс төрийг ноёрхож ирсэн МАН өнөөдөр ч намын системд давамгайлах байр суурьтай хэвээр байна. Хэдийгээр Монгол Улс төлөвшсөн ардчилалтай орны шалгууруудыг хангаж буй ч авторитар орнуудтай хил залгаа орны хувьд нэг намын хэт давамгайлал эрсдэлтэй болохыг судлаачид онцолдог (Fish & Seeberg, 2017). Намын систем дэх бүтцийн тогтвортой байдлыг хэмждэг бас нэгэн үзүүлэлт бол Блонделийн намын чансаа тодорхойлох индекс юм. Энэ нь хамгийн том хоёр намд ногдох парламентын суудлын хувь хэмжээ болон сонгуулиар авсан саналын хувь хэмжээг тус тус нийлүүлж тооцдог (Blondel 1968). Үүгээр голлох хоёр нам болох АН, МАН хамгийн тогтвортой, тэнцвэр хангасан үе нь 2004, 2008 онууд байжээ. Тухайлбал энэ үед хоёр намын сонгуулиар авсан санал ба парламент дахь суудлын нийлүүлсэн хувь хэмжээ 90-ээс дээш хувийг эзэлж байв (Зураг 1). Харин сонгуульд авсан санал ба парламентад эзлэх суудлын хувь хэмжээнд ихээхэн зөрүү гарсан онууд нь 1992, 2000, 2016, 2020 он байна. Энэ нь аль нэг нам нь хэт давамгайлсныг илэрхийлнэ.

**Зураг 1. Голлох хоёр намын сонгууль ба парламентад
эзлэх хувь хэмжээ, 1992–2020 он**

(Blondel's Ratio of Party Strength)



Эх сурвалж: СЕХ-ны мэдээлэлд үндэслэж, судлаачид тооцов

Судлаачид монголын намын системийг голдуу хоёр намын систем гэж тодорхойлсон байдаг. Гэхдээ намын системийн асуудал Монголын ардчилал, сонгуулийн талаарх судалгаа шинжилгээнүүдэд цухас дурдагдаж ирсэн юм. Монголын нам судлалын чиглэлээрх эрдэмтдээс Д.Болд-Эрдэнэ (2000) тухайн үеийн намын системийн хэвшинжийг ээлжит сонгуулиудын үр дүнгээр ангилан авч үзээд дараах байдлаар тодорхойлсон. Тэрээр намын системийг ерөнхийд нь 1) 1990–1992 он. шилжилтийн

үеийн завсрын систем; 2) 1992–1996 он. нэг нам зонхилсон систем; 3) 1996–2000 он. хоёр намын систем; 4) 2000 оноос хойших. нэг нам ба бусад гэж ангилжээ (Д.Болд-Эрдэнэ, 2000, х. 220).

Олон намын тогтолцоонд шилжсэн цагаас хойш өнөөг хүртэл нийт 8 удаагийн парламентын сонгууль зохион байгуулагдаж, МАН зургаад нь олонх болсноос хоёрт нь ердийн олонх, дөрөвт нь үнэмлэхүй олонхийг бүрдүүлжээ. Харин АН


хоёрт нь буюу 1996, 2012 онд тус тус парламентын олонхийг бүрдүүлж байв (Хүснэгт 10). Эрх баригч намууд сонгуулийн тогтолцоог тогтмол өөрчилж ирсэн учир өнөөг хүртэл Монголд сонгуулийн олон төрлийн хэлбэрүүдийг туршсан. Тэр дундаа сонгууль болохоос цөөн хэдэн сарын өмнө сонгуулийн тухай хууль өөрчлөгддөг байсныг энд тэмдэглэх нь зүйтэй юм.

2012 оныг эс тооцвол УИХ-ын ээлжит сонгуулиудыг томгосон (нэг тойрог олон мандат) ба жижигсгэсэн (нэг тойрог нэг мандат) плюралити хэлбэрээр зохион байгуулсан. Сонгуулийн энэхүү хэлбэр нь монголд хоёр намын системийг бий болгосон гэж үздэг (Croissant & Volkel, 2010). Харин 2012 оны УИХ-ын ээлжит сонгуульд анх удаа пропорциональ системийг нэвтрүүлэн, холимог хэлбэрээр явуулсан. 1992, 2008, 2020 оны сонгуулиуд 26 тойрогт хүн амын тоо, газар нутгийн байршил зэргээс хамаарч 2-4 мандатыг хуваарилсан бол 1996, 2000, 2004, 2016 оны сонгуулиудад 76 тойрог тус бүр нэг

мандаттайгаар зохион байгуулагдсан. Харин 2012 оны сонгуулийг холимог хэлбэрээр зохион байгуулахдаа 26 тойрогт 48 суудлыг 1-3 мандаттайгаар, үлдсэн 28 суудлыг намын жагсаалтын дагуу хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилжээ.

Олонхийн зарчмаар сонгогддог тогтолцоонд маргаан дагуулдаг нэг гол асуудал нь сонгогчдын санал гээгдэх явдал байдаг. Үүнийг нийт намуудын авсан санал ба суудлын хувь хэмжээний тэнцвэртэй харьцааг тооцдог Галлагерийн индексээр хэмжиж болно (Gallagher, 1991). Голлох хоёр намын чансааг тодорхойлсон өмнөх Блонделийн хэмжүүрийн адил 2004, 2008 онд намуудын авсан санал ба суудлын хэмжээ хамгийн тэнцвэртэй байв. Харин энэ тэнцвэр хамгийн их алдагдсан үе нь 2012 оны холимог тогтолцоогоор явуулсан сонгууль байна. Өнгөрсөн хугацаанд болсон нийт сонгуулиудын дундаж 25 хувь байгаа нь ихээхэн тэнцвэргүй үр дагавартай байгааг харуулж байна (Зураг 2).

**Зураг 2. Зохист харьцааны индекс
(Least Squares Index of Disproportionality), 1992–2020 он**



Эх сурвалж: СЕХ-ны мэдээлэлд үндэслэн тооцов

Сүүлийн гучин жилд эдийн засаг, нийгмийн ерөнхий нөхцөл байдал өөрчлөгдөж, хотжих үйл явц идэвхтэй өрнөсөн. Энэ хугацаанд хот, орон нутгийн хүн амын тоонд ихээхэн ялгаа гарсан ч УИХ дахь суудал хуваарилалт бодитой өөрчлөгдөөгүй. Хэдийгээр хүн амын тал гаруй хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг ч УИХ-ын суудлын дийлэнх нь орон нутагт хуваарилагдсаар ирсэн. Тухайлбал 1992 онд орон нутагт 52, нийслэлд 24; 1996, 2000, 2004, 2008 онуудад орон нутагт 56, нийслэлд 20; 2016 онд орон нутагт 48, нийслэлд 28;

2020 онд орон нутагт 52, нийслэлд 24 суудал тус тус хуваарилагджээ.

2012 оны пропорциональ элементийг оруулсан холимог тогтолцоо хоёр намын системийн задралыг тодорхой харуулдаг (Хүснэгт 3). Үр дүнд нь парламентад анх удаа гуравдагч улс төрийн хүчин 10-аас дээш суудлыг авсан. Мөн АН, МАН-аас бусад парламентад суудалтай хоёр нам, эвсэл нийлээд 28 хувийн дэмжлэг сонгуулиар авчээ. Гэвч 2016 онд олонхийн зарчмыг агуулсан сонгуулийн хэлбэрт буцаж шилжсэн.

Хүснэгт 3. Сонгогчдын тоо ба ирц, мянган хүн

	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Сонгогчид	1085.2	1147.3	1247.0	1329.8	1542.6	1840.8	1932.3	2000.6
Оролцсон	1037.4	1057.2	1028.0	1088.3	1179.5	1238.5	1424.5	1476.6
Ирц	95.6%	92.1%	82.4%	81.8%	76.5%	67.3%	73.7%	73.7%

Эх сурвалж. Сонгуулийн Ерөнхий Хороо

Монголын намын системийн талаарх тодорхойлолтуудыг ихэвчлэн сонгуулийн дүнд суурилсан байдлаар дүгнэж ирсэн. Харин Д.Болд-Эрдэнэ (2000) сонгуулийн дүнгээс гадна парламентын түвшинд намын системийг авч үзжээ. Тэрээр намын системийн нэг чухал хэв шинж болох эрх баригч ба сөрөг хүчний харилцааг тодруулж өгсөн. Шилжилтийн үед парламентад намын бүлгүүд бий болсон нь намын системд чухал үүрэг гүйцэтгэсэн ч намуудын өрсөлдөөн гишүүдэд төвлөрч байсан (Д.Болд-Эрдэнэ, 2000).

Харин Верена Фритц (2002) олон намын тогтолцоо бэхжихэд гадны туслалцаа ихээхэн чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэсэн байдаг. Тэр дундаа олон улсын байгууллагууд сөрөг хүчний намуудад арга зүйн болон бусад тусламж, дэмжлэгийг үзүүлсэн нь тэднийг бэхжихэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн байдаг (Фритц 2002, х. 89).

2.2 МОНГОЛЫН НАМЫН СИСТЕМИЙН ИНСТҮҮЧЛЭЛ

Улс төрийн намаар дамжуулж л ардчиллыг бий болгох боломжтой гэж үздэг олон онолууд байдаг. Үүнд сайн инстүүчлэгдсэн, тодорхой хэмжээний ялгарал бий болсон, хоорондоо өрсөлдөгч намууд л үр ашигтай, үр дүнтэй ардчилсан инстүүцийг бүрдүүлж чадна гэж үздэг. Гэхдээ нөгөө талаасаа иргэд нь хэт их хуваагдсан, ялгаатай байдал нь нийгмийн энэ чухал инстүүцийг төлөвшихөд сөргөөр нөлөөлж байдаг (Круасонт, Волкел, 2010).

Намын системийн инстүүчлэлийн талаарх ойлголт анх танилцуулагдсан цагаас хойш шинээр ардчилалд шилжсэн орнууд дахь намын системийн инстүүчлэлийн судалгаа олноор гарсан. Эдгээр судалгаанууд хуучин коммунист Зүүн Европ, Ази, Африкийн орнуудыг голдуу хамарсан байв. Гэвч өнөөг хүртэл монголын талаарх судалгаа шинжилгээ бараг байхгүй. Монголын намын системийн инстүүчлэл Круасонт, Волкел нарын 2010 онд хийсэн Зүүн Өмнөд Азийн орнуудын харьцуулсан шинжилгээнд л анх багтсан. Уг судалгаанд Алан Сиароффын намын системүүдийг хэв шинжээр нь тодорхойлсон ангилалд суурилан монголын намын

системийг 'хоёр намын систем'-д хамааруулсан байдаг. Энэ ангилал нь намын системийг сонгуультай холбож тодорхойлдог. Тэд монголын намын системийн инстүүчлэлийн түвшин өндөр байгааг хуучин холбож тайлбарлажээ. МАН-аас бусад намууд тогтвортой улс төрийн хүчин болж чадаагүй нь намуудын насжилт, саналын хэлбэлзлийн дүнгээс шууд харагддаг (Croissant & Volkel 2010).

Эдүгээ Монгол Улс бүс нутагтаа төдийгүй хуучин коммунист орнууд дотроо намын системийн хуваагдал хамгийн багатай орны тоонд багтаж байна (Croissant 2010 & Casal Bértoa 2017). Монголд олон намын тогтолцоонд шилжсэн цагаас хойш бүртгэлтэй улс төрийн намуудын тоо тогтвортой нэмэгдсээр ирсэн. Өдгөө 36 нам бүртгэлтэй байна. Нийт намуудын талаас илүү нь сүүлийн 10 жилд бүртгүүлжээ (Хүснэгт 11). Гэхдээ хамааралтай намууд (relevant parties) тоо өсөхгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Нийт 8 удаагийн сонгуулийн дүнгээр парламентийн үр ашигтай намын дундаж тоо 1.8 байгаа бол сонгуулийн үр ашигтай намын дундаж


2.9 байв. Хоёр индексээр хамгийн өндөр оноо 2012 онд гарчээ. Энэ дүн тус оны сонгуулийн системийн шинэтгэлтэй шууд холбоотой юм. Тухайлбал мөн онд парламентын үр ашигтай намын тоо 2.9 байгаа бол сонгуулийн үр ашигтай намын тоо 3.6 байв.

Хүснэгт 4. Үр ашигтай намын тоо, 1992-2020 он
(Effective Number of Parties)

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол


	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
ENEP	2.7	2.6	3.2	2.3	2.3	3.6	3.1	3.6
ENPP	1.2	1.9	1.1	2.2	2.1	2.9	1.3	1.4

Зураг 3. Монгол ба Зүүн Европын хуучин коммунист орнууд дахь сонгуулийн үр ашигтай намын дундаж тоо (1990-2016 он)



Эх сурвалж: Касал Бертау, Судлаачдын тооцоолол

Зураг 4. Монгол ба Зүүн Европын хуучин коммунист орнууд дахь парламентын үр ашигтай намын дундаж тоо (1990–2016 он)



Эх сурвалж: Касал Бертау, Судлаачдын тооцоолол

Харин Рэйгийн фракцчиллын индекс намуудын эзлэх хувь, эдгээр хувиудыг харьцуулж харуулдаг. Энэ үзүүлэлтээр Монголын намын системийг хэмжвэл дараах үр дүн харагдана.

Хүснэгт 5. Фракцчиллын индекс, 1992–2020 он (Rae's Fractionalization Index)

	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Electoral	0.61	0.58	0.67	0.53	0.52	0.72	0.63	0.67
Legislative	0.15	0.45	0.10	0.57	0.51	0.70	0.25	0.31

Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор

Монголын намын систем хаалттай байсныг батлах үзүүлэлт бол гучин жилийн хугацаанд монголын ерөнхийлөгч, ерөнхий сайдууд зөвхөн уг хоёр намд харъяалагдаж ирснээс харагдана.

2012 оны сонгуулийн дүнгээр үр ашигтай намын тоо болон Галлагерийн зохист харьцааны индекст огцом өөрчлөлт гарсан. Тухайлбал сонгуулийн үр ашигтай намын тоо 3 гарсан бол парламент дахь үр ашигтай намын тоо өмнө нь байгаагүй өндөр буюу 2.9 гарчээ. Харин намуудын авсан санал ба

парламентын суудлын зохист харьцаа 74.55 байв.

Тухайлбал үр ашигтай намын индексээр хамгийн өндөр дүн 3-тай гарсан байгаа нь дан ганц сонгуулийн тогтолцоонд хийсэн шинэтгэлээр тайлбарлагдах боломжгүй. Юуны өмнө энэ сонгуулийн өмнөх 2008 оны сонгуулиар ардчилалд шилжсэн цагаас хойш тохиож байгаагүй сонгуулийн хүчирхийлэл 07 сарын 01 бий болоод байсан юм. Үүнээс улбаатайгаар сонгуулийн ирц 67 хувь хүрч, түүхэнд байгаагүй доогуур ирцтэй сонгууль болсон билээ.

Хагас ерөнхийлөгчийн тогтолцоо

Элжигийн тодорхойлолтоор “Хагас ерөнхийлөгчийн гэж хууль тогтоох байгууллагадаа үүрэг хүлээдэг Засгийн газар, Ерөнхий сайдаас гадна олонхоор сонгогддог, хугацаат ерөнхийлөгч хоёул зэрэгцэн орших дэглэмийг хэлнэ” гэжээ. Сартори ерөнхийлөгчийн тогтолцоог “1) олонхоор сонгогдсон төрийн тэргүүн, 2) засгийн газраа томилж, чиглүүлдэг, 3) парламентын саналаар бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлөх боломжгүй” гэж тодорхойлжээ. Харин Мейнвэринг, Шугарт нар парламентын

тогтолцоонд 1) засгийн газрын тэргүүн парламентаас сонгогддогүй, мөн 2) бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд парламентын дэмжлэг, итгэлцэл хэрэг болдог гэжээ. Касал Бэртуа, Мейр нарын дэвшүүлсэн саналаар бол намын системийн инстүүчлэлд хамгийн чухал хүчин зүйл нь засгийн газрын төлөөх намууд хоорондын өрсөлдөөн байдаг (Касал Бэртуа, Мейр). Касал Бэртуа төрийн дэглэм намын системийн инстүүчлэлд хэрхэн нөлөөлдөг талаар судалгааг 2014 онд хийсэн байдаг (Касал Бэртуа, 2014).

Хэдийгээр Монгол Улс

парламентын тогтолцоотой орны тоондбагтдагч ерөнхийлөгчгүйцэтгэх засаглалын багагүй эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Ерөнхийлөгчийг парламентад суудалтай намууд бүх нийтийн сонгуульд нэр дэвшүүлж, сонгогчдын олонхийн саналаар 4 жилийн хугацаатай сонгогдож ирсэн. Өнгөрсөн хугацаанд 7 удаагийн ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдахад нийт 7 намын нэр дэвшигчид оролцсон. Гэхдээ үе үеийн ерөнхийлөгчид зөвхөн МАН, АН зэрэг намуудаас л зөвхөн сонгогдсон билээ (Хүснэгт 7). Үүнээс гадна ерөнхийлөгч парламентын баталсан хууль,

шийдвэрт хориг тавих эрх эдэлдэг. Монгол улсын хувьд 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш 1999 ба 2019 онд тус тус хоёр удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулжээ. 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгодог болсон.

Фернандо Касал Бертуагийн (2014) судалгаандаа хагас ерөнхийлөгчийн тогтолцоо нь улс төрийн намын инстүүчлэлд сөргөөр нөлөөлдөг гэжээ. Энэ нь манайд ч тодорхой харагддаг. Манай үе үеийн Ерөнхийлөгч нар намуудыг системийнх нь хувьд нураах алхамуудыг хийсэн жишээ олон бий.

Хүснэгт 6. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиудын дүн, 1993–2017 он

1993		1997		2001		2005	
Намууд	Санал	Намууд	Санал	Намууд	Санал	Намууд	Санал
МАХН	40.1%	МАХН	62.5%	МАХН	59.2%	МАХН	54.2%
МСДН	59.9%	АХЭ	30.6%	АН	37.2%	АН	20.2%
		МУНН	6.6%	ИЗН	3.6%	БНН	14.1%
						ЭОН	11.5%

2005		2013		2017			
Намууд	Санал	Намууд	Санал	Намууд	Санал	Намууд	Санал
МАХН	48.1%	МАН	42.5%	МАН	30.8%	МАН	44.9%
АН	51.9%	АН	50.9%	АН	38.6%	АН	55.2%
		МАХН	6.6%	МАХН	30.6%		

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо

Саналын хэлбэлзэл

Сонгогчдын саналын хэлбэлзэл шилжилтийн эхний 2 сонгуулиар хамгийн өндөр байв. Дунджаар 24 хувийн санал намуудын хооронд шилжсэн нь Зүүн Европын хуучин коммунист орнууд дахь шилжилтийн үетэй тун ойролцоо дүр зураг юм. Чех, Унгар, Польш, Словак зэрэг орнуудад болсон эхний хэдэн сонгуулиудаар намуудын хооронд шилжсэн санал

25 хувьтай байжээ. Ардчилалд шилжээд удаагүй орнуудад нийгмийн зааг ялгарал төдийлөн хүчтэй биш байхаас гадна сонгогчид харьцангуй нээлттэй байдаг. Ийм учраас сонгогчдын хувирамтгай байдал амархан тогтворждоггүй гэсэн Петер Мейрийн үндэслэлээр үүнийг тайлбарлаж болох юм (Maier 1997).

Хүснэгт 7. Монгол ба Зүүн Европын зарим орнууд дахь саналын хэлбэлзэл

Он	Монгол	Чех	Унгар	Польш	Эстони	Словень
1990–2000	23.7	22.1	29.5	24.1	23.5	25.1
2000–2010	14.2	17.4	11.5	31	25.4	24
2010–2020	13.2	34.6	23.2	19.8	15.1	42.3


Эх сурвалж. F. Casal Bértoa, "Database on WHO Governs in Europe and Beyond," (2017), whogoverns.eu

Монголд МАН-аас бусад намуудын байр суурь, орон зай удаан хугацаанд тогтвортой бус байгааг сонгуулиудын саналын хэлбэлзлээс харж болно (Зураг 5). МАН өнөөг хүртэл сонгуулиудад дунджаар нийт сонгогчдын 46 хувийн дэмжлэг авч, байр сууриа тогтвортой хадгалсаар

иржээ. Харин энэ хугацаанд АН дунджаар 33 хувийн дэмжлэгтэй байв (Хүснэгт 10).

Мөн үүнээс гадна хоёр намын системийг бүрэлдүүлэгч гол хоёр намын нэг болох АН-ын байр суурь, орон зай хумигдсаар байгаа нь эндээс харагдаж байна.

Зураг 5. Саналын хэлбэлзэл, 1992–2020 он (Pedersen's Index of Electoral Volatility)



Эх сурвалж: СЕХ-ны мэдээлэлд үндэслэж тооцов


УДШ дээрх улс төрийн намуудын бүртэл мэдээллийн дагуу ойролцоогоор 3 сонгогч тутмын 1 нь ямар нэг улс төрийн намд харъяалалтай байна. Үүнд МАН, АН зэрэг аймаг, сум бүрт намын анхан шатны нэгжтэй голлох хоёр намын гишүүнчлэл томоохон байр суурь эзэлнэ (Хүснэгт 10). Гишүүнчлэлийн тоо бодитой эсэхийг баталгаажуулах процесс байхгүй учир намууд гишүүдийн тоогоо ихэсгэж бүртгүүлэх хандлагатай байдаг. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд улс төрийн намтай холбоотой хэд хэдэн

зүйл заалтыг оруулсан. Энэ дотроос ихээхэн зөрчил дагуулсан нэг зүйл заалт нь намын бүртгэлд тавигдах гишүүнчлэлийн босго шаардлагыг өндөрсгөсөн явдал байв. Тухайлбал Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т: “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” хэмээх зүйл заалтыг 2028 оноос хэрэгжиж эхлэхээр тусгажээ. Энэхүү өөрчлөлтөөс өмнө 801 гишүүнтэй улс төрийн намыг бүртгэх зохицуулалт үйлчилж ирсэн. Өмнө дурдсанчлан одоо бүртгэлтэй

байгаа намуудын талаас илүү нь сүүлийн 10 жилд бүртгүүлсэн байдаг. Эдгээр намуудаас зөвхөн МАХН бүртгэлийн энэхүү шаардлагад нийцэж байгаа юм. Иймд уг өөрчлөлт нь олон гишүүнтэй, парламентын намуудын байр суурийг баталгаажуулахад чиглэжээ.

Гэхдээ монголд саналын хэлбэлзэл Зүүн Европын орнуудтай харьцуулахад бага байгааг доорх зургаас харж болно. Барууны ардчилсан орнуудад нийгмийн зааг ялгарал хүчтэй бэхжсэнээр намуудын хоорондын өрсөлдөөн, нийгэмд эзлэх байр суурь тогтворжих нэг гол нөхцөл болсон байдаг.

Зураг 6. Монгол ба Зүүн Европын хуучин коммунист орнууд дахь саналын дундаж хэлбэлзэл (1990–2016 он)




Эх сурвалж. F. Casal Bértoa, "Database on WHO Governs in Europe and Beyond," PSgo (2017), whogoverns.eu

Намын системийн хаалттай байдал

Дээр дурдсанчлан намын системийн инстүүчлэлийг тооцдог нэг аргачлал бол Мэйр, Касал Бертуйа нарын намын системийн хаалттай байдал. Монголын намын системийг Касал Бертуйагийн тооцоолсноор Монгол Улс намын системийн хаалттай байдлын индексээр 89.1 оноотой байна (Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 12-с харна уу.) Зүүн Европын хуучин коммунист орнуудын дундаж оноо 86 байна. Өөрөөр хэлбэл намын систем нь инстүүчлэгдсэн гэдгийг илэрхийлж байна.

Зураг 7. Монгол ба Зүүн Европын хуучин коммунист орнууд дахь намын системийн хаалттай байдал (Намын системийн инстүүчлэл) (1990–2016 он)



Эх сурвалж. F. Casal Bértoa, "Database on WHO Governs in Europe and Beyond," PSgo (2017), whogoverns.eu

ДҮГНЭЛТ

Зураг 7-оос харахад Монголын намын систем Зүүн Европын орнуудтай харьцуулахад хамгийн өндөр оноотой байна. Монголд намын систем инстүүчлэгдсэн болох нь дээрх зургуудаас харагдаж байна. Касал Бертаугийн аргачлалаар тооцоход 100 оноос 89.1 оноо авсан байна. Дээрх харьцуулсан 15 орноос Унгарын дараа хоёрт орж байна. Монтенегро нь зөвхөн 2009 оноос 2014 оны өгөгдөл дээр хийсэн тоо харьцуулж хэлэхэд учир дутагдалтай.

Мөн саналын хэлбэлзэл буюу electoral volatility гэх үзүүлэлтээр 14.8 оноо буюу пост коммунист орнууд дундаа хамгийн сайн үзүүлэлттэй юм. Энэ нь Монголд нэг намаас нөгөө намд сонгогчдын санал хэлбэлзэх нь харьцангуй бага байна гэсэн үг. Жишээлбэл 2010-2020 оны хооронд Унгар 23.2, Польш 19.8 хувьтай санал хэлбэлзсэн бол Монголд 13.2 хувьтай байжээ. Энэ нь сонгогчдын санал харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна. Сонгогчдын санал тогтвортой байна гэдэг бол дээрх намуудад сонгогчид итгэж байгааг бодитоор харуулж байна.

Мөн Монголд сонгуулийн үр ашигтай намын тоо 2.8 байна. Харин парламентийн үр ашигтай намын тоо нь 1.8 байна. Үүнийг Унгар, Польш болон бусад пост коммунист орнуудтай харьцуулахад харьцангуй бага гэсэн үг. Намын системийн хуваагдал хамгийн багатай орон болох нь харагдаж байна. Учир шалтгаан нь сонгуулийн системтэй холбоотой гэж зарим судлаачид үздэг. Дээр харьцуулсан пост коммунист орнууд ихэнх нь пропорциональ, үлдсэн хэсэг холимог системээр сонгуулиа зохион байгуулдаг. Харин Монголын хувьд нийтдээ 8 сонгуулийн 7-д нь олонхийн системийг ашигласан байдаг. Энэ нь Дувержегийн онолоор цөөн тооны буюу хоёр нам, зарим тохиолдолд Зонхилогч намын системийг бүрдүүлдэг байна.

Зураг 1-т үзүүлсэн Блонделийн Намын чансааны индекст (Ratio of Party Strength)-ээс харахад голлох хоёр нам намын системд ямар байр суурьтай байгааг харуулсан. Эндээс харахад хоёр намын парламент дахь суудлын хэмжээ нь 90-ээс дээш хувьтай байна. Гэхдээ уг хоёр намын сонгуульд авсан санал, парламентад

эзлэх хувь нь их зөрөөтэй байгаа нь сонгуулийн тогтолцооны гажгийг харуулж байна гэж хэлж болно. Мөн зурагт 2-т үзүүлэн Зохист харьцааны индексээс харахад 2004, 2008 онд намуудын авсан санал хамгийн тэнцвэртэй байна. Гэхдээ өнгөрсөн 30 жилийн дундаж дүнгээр харахад 25 хувьтай байгаа нь тэнцвэргүй буюу зохист харьцаа алдагдсаныг илэрхийлж байна.

Эцэст нь дүгнэхэд Монголд Улс төрийн намын систем инсүүтчлэгджээ. Энэ нь олон талын ач холбогдолтой. Улс төр судлаач Фернандо Касал Бертуагийн (2017) үзэж байгаагаар улс төрийн намын системийн инсүүчлэгдсэн байх нь дараах гурван гол ач холбогдолтой.

1. Улс төрийн намын системийн инсүүчлэл нь Европт ардчилал хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн.
2. Улс төрийн намын системийн инсүүчлэгдсэн гэх босгыг давсан орнууд ардчиллаас буцдаггүй.
3. Системийн хувьд хэт инсүүчлэгдэх нь сул талтай ч, ардчилалд ч хортой зүйл биш (Касал Бертуа, 2017).

Касал Бертуагийн эмпирик судалгаан дээр үндэслэсэн дүгнэлтээс харахад Монгол улсад намын систем инсүүчлэгдсэн нь Монгол орон ардчиллаас буцахгүй юм байна гэсэн итгэлийг төрүүлж байна.

Жич: Энэхүү судалгаа нь Монголын Улс төрийн намын системийг, уг систем нь хэр зэрэг инсүүчлэгдсэн байгааг танин мэдэх зорилготой позитив судалгаа юм. Тийм учраас цаашид хэрхэх нь зөв талаар бодлогын зөвлөмж (норматив) өгөхийг зорьсонгүй.

2020.06.30

НОМ ЗҮЙ

- ◆ Болд-Эрдэнэ, Д. (2000) Монголын улс төрийн нам, намын систем, Улаанбаатар, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Философи, Социологи, Эрхийн Хүрээлэн
- ◆ Гэрэлт-Од, Э Монголын ардчилал ба улс төрийн намууд
- ◆ Чимид,Б (2006) Өнөөгийн улс төр: Хуульчийн нүдээр, Адмон хэвлэл, Улаанбаатар
- ◆ Barkmann, U. (2005) Understanding Modern East Asian Politics. Political Parties and the Democratic Process in Mongolia.
- ◆ Blondel, J. (1968) Party systems and patterns of government in Western democracies, Canadian Journal of Political Science, 1, pp. 180–203.
- ◆ Birch S. (2003) Party System Stability and Change. In: Electoral Systems and Political Transformation in Post-Communist Europe. One Europe or Several?. Palgrave Macmillan, London
- ◆ Casal Bértoa, F. & Uribe Burcher, C. (2018) Political Finance in Mongolia – Assessment & Recommendations
- ◆ Casal Bértoa, F. (2017). Political parties or party systems? Assessing the ‘myth’ of institutionalisation and democracy. West European Politics, 40(2), 402-429. Open Society Forum & International IDEA
- ◆ Casal Bértoa, F. (2014) Does the Type of Regime Matter? On the Perils of Presidential Elections for Party System Institutionalization in Europe.
- ◆ Casal Bértoa, F. (2012) Parties, regime and cleavages: explaining party system institutionalisation in East Central Europe.
- ◆ Casal Bértoa, F. (2010) Party system closure: conceptualization, operationalization, and validation. DISC Working Paper Series no. 11.
- ◆ Croissant, A. & Völkel, P. (2010) Party system types and party system institutionalization: Comparing new democracies in East and Southeast Asia. Party

Politics, 18:2, 235-265

- ◆ Duverger, M. (1954). *Political Parties: Their Organisation and Activity in The-modern State*. Methuen & Company.
- ◆ Gallagher, M. (1991) Proportionality, disproportionality and electoral systems, *Electoral Studies*, 10(1), pp. 33–51.
- ◆ Giovanni, S. (1976). *Parties and Party Systems: a framework for analysis*.
- ◆ Enyedi, Z., & Casal Bértoa, F. (2018). Institutionalization and de-institutionalization in post-communist party systems. *East European Politics and Societies*, 32(3), 422-450.
- ◆ Katz, R. S., & Mair, P. (1993). The evolution of party organizations in Europe: the three faces of party organization. *American review of politics*, 14, 593-617.
- ◆ Kopecký, P. (1995). Developing party organizations in East-Central Europe: what type of party is likely to emerge?. *Party Politics*, 1(4), 515-534.
- ◆ Krupavičius, A. (2004). Party systems in Central East Europe. *Lithuanian political science yearbook*, (01), 31-55.
- ◆ Fritz, V. (2002) Mongolia: Dependent Democratization, *Journal of Communist Studies and Transition Politics*, 18:4, 75-100
- ◆ Fish, M. S., & Seeberg, M. (2017). The secret supports of Mongolian democracy. *Journal of Democracy*, 28(1), 129-143.
- ◆ Fish, M. S. (1998). Mongolia: democracy without prerequisites. *Journal of democracy*, 9(3), 127-141.
- ◆ Fritz, V. (2008) Mongolia: The Rise and Travails of a Deviant Democracy, *Democratization*, 15:4, 766-788
- ◆ Laakso, M. & Taagepera, R. (1979) Effective number of parties: A measure

with application to Western Europe, *Comparative Political Studies*, 12, pp. 3–27.

- ♦ Pedersen, M. N. (1979). The dynamics of European party systems: changing patterns of electoral volatility. *European journal of political research*, 7(1), 1-26.
- ♦ Mainwaring, S. (2018) *Party Systems in Latin America: Institutionalization, Decay, & Collsape* (Cambridge University Press).
- ♦ Mainwaring, S. & Scully, T. R. (1995) *Building Democratic Institutions. Party Systems in Latin America* (Stanford, CA: Stanford University Press).
- ♦ Mair, P. (1997) *Party System Change* (Oxford: Oxford University Press).
- ♦ Mair, P. (2006) Party system change, in: R. S. Katz & W. Crotty (Eds) *Handbook of Party Politics* (London: Sage).
- ♦ Rae, D. (1967) *The Political Consequences of Electoral Laws* (New Haven, CT: Yale University Press).
- ♦ Reynolds, A., & Reilly, B. (1997). The international IDEA handbook of electoral system design (Vol. 1). International idea.
- ♦ Schattschneider, E. E. (1942). *Party Government*. New York: Farrar and Rinehart. Inc.
- ♦ Samuel, P. (1989). Huntington (1968). *Political order in changing societies*, 146.
- ♦ Sartori, G. (1969). Politics, ideology, and belief systems. *American Political Science Review*, 63(2), 398-411.

ХАВСРАЛТ

Хүснэгт 8. Бүртгэлтэй улс төрийн намуудын жагсаалт, 2020 оны 5 дугаар сарын байдлаар

№	Намын нэр	Намын дарга	Гишүүдийн тоо	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо
1	Монгол Ардын Нам (МАН)	У.Хүрэлсүх	161300	1921.03.01	1990.05.16
2	Ардчилсан Нам (АН)	С.Эрдэнэ	150000	2000.12.06	2000.12.06
3	Монголын Ногоон Нам (МНН)	О.Бум-Ялагч	2100	1990.05.13	1990.05.26
4	Иргэний Зориг Ногоон Нам (ИЗНН)	Ц.Ганхуяг	35000	2000.03.09	2000.03.23
5	Монголын Уламжлалын Нэгдсэн Нам (МУНН)	Б.Батболд	1503	1993.12.05	1994.01.14
6	Монгол Либерал Ардчилсан Нам (МЛАН)	Т.Төмөрмөнх	863	1998.03.05	1998.05.21
7	Эх Орон Нам (ЭОН)	Б.Эрдэнэбат	160000	1998.12.22	1998.12.22
8	Монголын Либерал Нам (МЛН)	Б.Амгаланбаатар	1300	1999.12.17	2000.01.28
9	Бүгд Найрамдах Нам (БНН)	Б.Жаргалсайхан	50000	2004.03.15	2004.04.05
10	Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам (МЭҮН)	Г.Тунгалаггэрэл	1069	2003.12.16	2004.04.12

№	Намын нэр	Намын дарга	Гишүүдийн тоо	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо
11	Монголын Социал Демократ Нам (МСДН)	А.Ганбаатар	3000	2004.12.19	2005.01.20
12	Ард Түмний Нам (АТН)	Н.Наранцогт	11859	2005.12.11	2005.12.21
13	Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН)	Б.Цогтгэрэл	26000	2006.05.19	2006.07.10
14	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам (ЭЧХН)	Ш.Төмөрсүх	1600	2006.10.09	2007.02.09
15	Иргэний Хөдөлгөөний Нам (ИХН)	Б.Батсайхан	815	2007.08.17	2007.10.17
16	Хөгжлийн Хөтөлбөрийн Нам (ХХН)	О.Заяа	933	2007.10.28	2007.10.30
17	Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам (МОНАРХН)	Т.Оюунаа	850	2008.02.01	2008.02.01
18	Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)	Н.Энхбаяр	35000	2011.01.28	2011.06.24
19	Хамуг Монголын Хөдөлмөрийн Нам (ХМХН)	Ц.Шинэбаяр	2000	2011.09.23	2011.10.21

№	Намын нэр	Намын дарга	Гишүүдийн тоо	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо
20	Хөдөлмөрийн Үндэсний Нам (ХҮН)	Б.Найдалаа	1024	2011.11.05	2011.12.05
21	Эх Орончдын Нэгдсэн Нам (ЭОНН)	Г.Ганбат	2150	2012.01.20	2012.03.12
22	Монгол Консерватив Нам (МКН)	Н.Дашдаваа	959	2012.06.20	2012.10.23
23	Тусгаар Тогтнол, Эв Нэгдлийн Нам (ТТЭНН)	Ц.Баянбилэг	3131	2015.04.18	2015.05.29
24	Ард Түмнээ Хайрлая Нам (АТХН)	Л.Гүндалай	1388	2015.04.20	2015.06.26
25	Монголын Хүний Төлөө Нам (МХТН)	Х.Бат-Ялалт	1135	2017.02.17	2017.04.21
26	Үнэн ба Зөв Нам (ҮБЗН)	А.Отгонбаатар	819	2017.03.10	2017.06.07
27	Зон Олны Нам (ЗОН)	Г.Эрдэнэтөгс	2022	2017.06.12	2017.06.30
29	Дэлхийн Монголчууд Нам (ДМН)	Г.Тэмүүжин	1022	2018.01.15	2018.03.05
29	Ард Түмний Олонхийн Засаглал Нам (АТОЗН)	А.Батдорж	1080	2018.08.26	2018.12.21

№	Намын нэр	Намын дарга	Гишүүдийн тоо	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо
30	Их Эв Нам (ИЭН)	З.Бат-Отгон	1056	2018.09.29	2018.12.21
31	Гэр Хороолол Хөгжлийн Нам (ГХХН)	Б.Батсүх	1023	2018.11.28	2019.01.07
32	Миний Монгол Нам (ММН)	Ж.Бат-Ирээдүй	979	2019.04.10	2019.05.06
33	Монгол Шинэчлэлт Нам (МШН)	Н.Жамсран	1210	2018.10.19	2019.06.26
34	Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Нам (ШИНЭН)	Ж.Батзандан	913	2019.06.06	2019.09.12
35	Зүй Ёс Нам (ЗЁН)	Б.Насанбилэг	1533	2019.06.08	2019.09.12
36	Ардчилал Шинэчлэлийн Нам	Э.Бямбацэрэн	893	2019.12.18	2020.02.21

Эх сурвалж: Улсын Дээд Шүүх

**Хүснэгт 9. УИХ-ын ээлжит сонгуулиудын дүн
(УИХ-д суудалтай намуудаар), 1992–2020 он**

1992			1996			2000		
Намууд	Санал	Суудал	Намууд	Санал	Суудал	Намууд	Санал	Суудал
МАН	56.9%	70	МАН	40.5%	25	МАН	51.6%	72
МоАН	17.5%	4	АХЭ	47.0%	50	АХЭ	13.4%	1
МСДН	10.1%	1	МУНН	1.8%	1	МАСН	11.0%	1
2004			2008			2012		
Намууд	Санал	Суудал	Намууд	Санал	Суудал	Намууд	Санал	Суудал
МАН	48.2%	36	МАН	52.7%	45	МАН	31.3%	26
ЭОАЭ	44.3%	34	АН	40.4%	28	АН	35.3%	34
БНН	1.4%	1	ИЗН	1.97%	1	ИЗНН	5.5%	2
МНН	1.42%	1	МНН	1.42%	1	ШЁЭ	22.3%	11
2016			2020					
Намууд	Санал	Суудал	Намууд	Санал	Суудал			
МАН	45.1%	65	МАН	44.9%	62			
АН	33.1%	9	АН	24.5%	11			
МАХН	8.0%	1	ТБЭ	8.1%	1			
			ЗХЭЭ	5.2%	1			

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо

Хүснэгт 10. Монголын намын систем, шалгуур үзүүлэлтүүдээр, 1992–2020 он

Шалгуур үзүүлэлтүүд	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Сонгуулийн фракциллын индекс	0.61	0.58	0.67	0.53	0.52	0.72	0.63	0.67
Парламентын фракциллын индекс	0.15	0.45	0.10	0.57	0.51	0.70	0.25	0.31
Сонгуулийн үр ашигтай намын тоо	2.7	2.6	3.2	2.3	2.3	3.6	3.1	3.6
Парламентын үр ашигтай намын тоо	1.2	1.9	1.1	2.2	2.1	2.9	1.3	1.4
Блонделын сонгуулийн намын чансааны индекс	74.4	87.5	65.0	92.5	93.1	62.9	78.3	69.4
Блонделын парламентын намын чансааны индекс	97.4	98.7	96.1	92.1	96.1	73.7	97.4	96.05
Галлагерийн зохист харьцааны индекс	27.34	14.64	33.25	2.02	5.29	74.55	32.73	27.73
Педерсений саналын хэлбэлзлийн индекс	-	19.4	28.1	10.1	4.6	6.5	20.3	12.8

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо

*Хүснэгт 11. Унгар, Литви орны намын системийн
институцчилалд үзүүлэх төсвийн санхүүжилтийн нөлөө*

Улс	Хугацаа (Сонгуулийн тоо)	Нийт сонгуулийн намууд	Жижиг намын авсан санал	Намын оршин тогтнох үнэлгээ
Унгар	1990–2010 (6)	9.2	9.7	94 (40)
	1992–2010 (5)	14.8	20.4	NA (52.4)
Литви	1992–1999 (2)	16.5	24.4	NA (73.5)
	2000–2010 (3)	13.7	17.7	95 (31.3)

Хүснэгт 12. Намын системийн хаалттай байдлын индекс: Монгол

	IGA/Засгийн газрын бүрэлдэхүүн	IFA / Хэвшмэл засгийн газар	IC / Нээлттэй байдал
1992	FG	FG	FG
1993	100	100	100
1994	100	100	100
1995	100	100	100
1996	100	100	100
1997	100	0	0
1998	100	100	100
1999	100	100	100
2000	100	100	100
2001	100	100	100
2002	100	100	100
2003	100	100	100
2004	58.8	29.4	88.1
2005	100	100	100
2006	81.1	84.6	84.6
2007	89.8	91.3	95.5
2008	50	88.2	100
2009	100	100	100
2010	100	100	100
2011	100	100	100
2012	75	55.6	91.7
2013	100	100	100
2014	66.6	66.7	100
2015	66.6	66.7	100
2016	100	100	100
2017	100	100	100
2018	100	100	100
2019	100	100	100
iPSI (27)=89.1	92.1	88.2	94.8
iPSI = (84.2+88.2+94.8)/3=89.1	Closure = (92.1-50)*2 =84.2		

DeFacto

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

ДЕФАКТО ИНСТИТУТ

Дефакто институт нь улс төрийн намаас хараат бус, бие даасан, ашгийн бус судалгааны төв юм. Бид улс төр, эдийн засгийн судалгаанууд хийх бөгөөд түүний дотор ардчилал, зах зээлийн эдийн засаг, хязгаарлалттай засаг, шинийг бүтээх (инноваци) зэрэг чиглэлд төвлөрч ажилладаг. Бид судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах орчин үеийн хандлагыг төлөвшүүлж бэхжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗОРИЛГО

Мэргэжлийн өндөр түвшний, хараат бус судалгаагаар нөлөөлж хуулийн засаглалыг бэхжүүлэх, ардчилсан нийгмийн үнэт зүйлүүд болох нээлттэй, тайлагнадаг, хариуцлагатай засаглал бий болгох, зах зээлд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь манай эрхэм зорилго юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Эдийн засаг, улс төрийн өнөөгийн нөхцөлд байдалд дүн шинжилгээ хийх, хамгийн чухал асуудлуудыг сонгон авч судалгаа хийх, шийдэл санал болгох;
- Өнөөгийн бодлогын алдааг засаж, сайжруулахад нь бодлого боловсруулагчидад дэмжлэг үзүүлэх;
- Эдийн засаг, улс төрийн чухал асуудлуудаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх;
- Төр засгийг нээлттэй, тайлагнадаг болгож хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог дэмжих;

ХОЛБОО БАРИХ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62

E-mail: origo@jargaldefacto.com

Вебсайт: <http://defacto.mn/>

Facebook: The Defacto Institute

Twitter: @defactomn

